

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХАРИЛЦАН ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ,  
ХАМГААЛАХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛ-  
СЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Най-  
рамдах Франц Улсын Засгийн газар /Хэлэлцэн тохирогч Талууд/

хоёр улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг бэх-  
жүүлэх, Монголоос Францад, Францаас Монголд хөрөнгө оруулах  
таатай нөхцөл бүрэлдүүлэхийг эрмэлзэн,

ийнхүү хөрөнгө оруулахыг хөхүүлэн дэмжих, хамгаалах нь  
хоёр орны эдийн засгийн хөгжлийн тусын тулд тэдний хооронд хө-  
рөнгө, технологи шилжих үйл явцад түлхэц болно гэдэгт төгс  
итгэн,

доорх зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрт:

I. "Хөрөнгө оруулалт" гэсэн нэр томъёонд шинж чанараас нь  
хамааран бүх төрлийн үнэ өртөг бүхий бараа, эрх ашиг, сонир-  
хол, тухайлбал дор дурдах зүйлийг хамруулах боловч тэдгээр нь  
үүгээр үл хязгаарлагдана:

а/ хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө, тэрчлэн дэнчин, эрх  
дарх, саатуулан барьцаалах эрх, бусдын өмчийг ашиглах эрх, барь-  
цаа болон тэдгээртэй адилтгах аливаа бусад эрх;

2.

б/ Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутагт байгуулагдсан компанийн хувьцаа, хувьцаа гаргаснаас болон компанийн өмчөөс бүр баганхыг буюу шууд бусаар эзэмшиж байгаагаас орох аливаа ашиг;

в/ облигац, төлөх ёстой мөнгө болон бусад үнэт цаасны төлбөр;

г/ зохиогчийн эрх, үйлдвэрлэлийн өмчийн эрх /тухайлбал патент, лиценз, барааны тэмдэг, үйлдвэрлэлийн загвар, макет/ техникийн ажилбар, компаний нэр, компаний нэр хүнд;

д/ хууль тогтоомжийн дагуу болон контрактаас үүдэн гарах үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл /концесс/, тухайлбал хэлэлцэн тохирогч нөгөө Талын харьяа далай, тэнгисийн газрыг нь ч оролцуулан түүний бүх нутаг дэвсгэрт байгалийн баялгийг эрж хайх, ургуулах, олборлох, боловсруулах, ашиглах зөвшөөрөл.

Дурдсан хөрөнгө оруулалтад энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнөх буюу хүчин төгөлдөр болсноос хойшхи хугацаанд Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу түүний нутаг дэвсгэр болон харьяа далай, тэнгисийн газарт оруулсан буюу оруулж болох хөрөнгө оруулалтыг хамруулж ойлгоно.

Хөрөнгө оруулалт хийсэн үнэ өртөг бүхий зүйлийн хэлбэр өөрчлөгдөх явдал нь тэдгээрийн хөрөнгө оруулалтын хувьд агуулж буй шинж чанарт нөлөөлөхгүй боловч нутагт нь болон харьяа далай, тэнгисийн газарт хөрөнгө оруулсан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хууль тогтоомжид харшлахгүй.

2. "Иргэн" гэсэн нэр томъёо нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн-хувь хүнийг хэлнэ.

3.

3. "Компани" гэсэн нэр томъёо нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутагт түүний хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан тэнд удирдах байгууллага нь байрладаг, эсхүл Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд шууд болон шууд бусаар хянадаг, эсхүл түүний хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийн хяналтад байдаг хуулийн этгээдийг нэрлэнэ.

4. "Өгөөж" гэсэн нэр томъёо нь хөрөнгө оруулалтын үр дүнд тодорхой хугацаанд олсон ашиг, роялт, хүү зэрэг орлогыг нэрлэнэ. Хөрөнгө оруулалтын өгөөж, дахин хөрөнгө оруулалт хийх тохиолдолд түүнээс олох өгөөж нь үндсэн хөрөнгө оруулалтын адил хамгаалалтад байна.

5. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр, түүнчлэн Хэлэлцэн тохирогч Талуудын харьяа далай, тэнгисийн газар буюу байгалийн баялгийг нь эрж хайх, боловсруулан ашиглах, хамгаалах эрхийг хэлэлцэн тохирогч Талд олон улсын хууль эрхийн дагуу хүлээн зөвшөөрсөн эдийн засгийн бүс, эх газрын хөрмөй болон нутгийн усанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутагт болон харьяа далай, тэнгисийн газарт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд, компаниас хөрөнгө оруулахыг үндэсний хууль тогтоомж, энэхүү Хэлэлцээрийн заалтуудын дагуу хөхүүлэн дэмжиж, хүлээн авна.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль ч Тал өөрийн нутагт болон харьяа далай, тэнгисийн газарт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд болон

компаниас оруулсан хөрөнгөд олон улсын хууль зүйн зарчмуудын дагуу шударга, эрх тэгш хандах бөгөөд ийнхүү хүлээн зөвшөөрсөн эрхээ эдлэх явцад нь хуулиар болон тодорхой ажиллагаагаар саад учруулахгүй гэдгээ батлан даана. Дээр дурдсан зүйлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

-Түүхий эд, туслах материал, эрчим хүч, шатахуун, үйлдвэрлэлийн бүх төрлийн хэрэгслийг худалдан авах, тээвэрлэх, түүнчлэн бүтээгдэхүүнээ дотоодын болон гадаадын зах зээл дээр борлуулах, тээвэрлэхэд хуулиар буюу үйл ажиллагаагаар ямарваа саад бэрхшээл учруулах, мөн үүнтэй адилтгах аливаа арга хэмжээг авахгүй байна.

-Талууд хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдээс хөрөнгө оруулж буй нутаг дэвсгэр, далай тэнгисийн газарт орж ирэх, зочлох, ажиллах, шилжин явах талаар гаргасан хүсэлтийг үндэснийхээ хууль тогтоомжийн хүрээнд нааштайгаар хүлээн авч шийдвэрлэж байна.

#### Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутагт болон харьяа далай тэнгисийн газарт нөгөө Талын иргэд, компанийн зүгээс хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалттай холбогдсон үйл ажиллагаа явуулахад тэдэнд өөрийн иргэд болон компанид олгодог, эсхүл илүү тааламжтай бол үндэстний нэн тааламжтай нөхцөл олгосон орны иргэд, компанид олгодог нөхцөлөөс дутуугүй тааламжтай нөхцөл олгоно. Үүнтэй холбогдон Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг болон түүний харьяа далай тэнгисийн газарт ажиллах зөвшөөрөл бүхий иргэд өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа эд материалын хөнгөлөлт эдэлнэ.

Энэхүү хандлага нь Хэлэлцэн тохирогч нэг Талаас гуравдагч улсын иргэд, компанид чөлөөт худалдааны бүс, гаалийн холбоо, нийтийн зах зээл болон бүс нутгийн эдийн засгийн байгууллагын аливаа хэлбэрт оролцдог, эсхүл нэгдсэний улмаас олгодог хөнгөлөлтөд үл хамаарна.

#### Тавдугаар зүйл

I.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд, компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг, харьяа тэнгисийн газарт оруулсан хөрөнгө нь бүрэн бөгөөд бүх талын хамгаалалт болон аюулгүй байдалд байна.

2.Хэлэлцэн тохирогч аль ч Тал өөрийн нутаг, харьяа тэнгисийн газарт улсын эрх ашгийг хангах зорилгоор, ялгаварлан гадуурхахгүй нөхцөлд, онцгой байдлаар үүрэг хүлээгээгүй үед Хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэд, компанийн оруулсан хөрөнгийг дайчлан гаргуулах, улсын өмч болгох хийгээд шууд болон шууд бусаар өмчийн эрхийг нь үгүйсгэх аливаа арга хэмжээ авахгүй.

Өмчийн эрхийг үгүйсгэх аливаа арга хэмжээ нь цаг тухайдаа зохих ёсоор нөхөн төлөгдөх бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг гаргахдаа тухайн хөрөнгө оруулалтын бодит өртөгт үндэслэж, өмчийн эрхийг үгүйсгэх аюул тулгарахаас өмнө давамгайлж байсан эдийн засгийн ердийн байдлын дагуу тодорхойлно.

Дурдсан нөхөн төлбөр, төлбөрийн хэмжээ болон нөхцөлийг өмчийн эрхийг үгүйсгэх өдрөөс өмнө тодорхойлно.Нөхөн төлбөр нь хэрэгжих бүрэн боломжтой байх бөгөөд мөнгийг хойшлуулалгүй даруй гуйвуулж гүйцэтгэнэ.Төлбөрийг хийх хүртэл түүний хууг зах зээлийн тохирох ханшаар тооцож төлнө.

3. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг, харьяа тэнгисийн газарт болсон дайн болон аливаа бусад зэвсэгт мөргөлдөөн, хувьсгал, бослого гарах, үндэсний онц байдал тогтоосны улмаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд, компанийн хөрөнгө оруулалтад хохирол учирвал Хэлэлцэн тохирогч энэхүү Талаас өөрийн буюу үндэстний нэн тааламжтай нөхцөл олгосон улсын иргэд болон компанид олгох нөхцөлөөс дутуугүй таатай нөхцөлийг хохирол хүлээж буй нөгөө талын иргэд, компанид олгоно.

#### Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг, харьяа тэнгисийн газарт хөрөнгөө оруулсан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд, компанийн дор дурдсан өгөөжийг чөлөөтэй гуйвуулах баталгаа өгнө:

- а/ хүү, ногдол ашиг, ашиг болон бусад цаг үеийн орлого;
- б/ нэгдүгээр зүйлийн I дүгээр заалтын "г" болон "д"-д дурдсан өмчийн эрхээс үүсэх роялт;
- в/ тогтмол хийгдэж байсан зээлийн төлбөр;
- г/ хөрөнгө оруулалтаас үүсэх хөрөнгийн үнийн өсөлтийг оролцуулан хөрөнгө оруулалтыг хэсэгчлэн болон бүхэлд нь татан буулгасны өртөг;
- д/ 5 дугаар зүйлийн 2, 3-т дурдсан өмчийг хураахтай холбогдож гарсан нөхөн төлбөр, хохирол.

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг, харьяа тэнгисийн газарт зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалттай холбогдон хөрөнгө оруулагч Талын тэнд ажиллах зөвшөөрөл бүхий иргэд цалин хөлснийхээ зохих хэсгийг эх орондоо гуйвуулах боломжтой байна.

Дээрх заалтуудад дурдсан гуйвуулгыг хугацаанд нь хийхдээ тухайн өдөр нь хэрэглэгдэж буй албан ёсны ханшийг баримтална.

#### Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын хуулийн зохицуулалтын дагуу гадаадад оруулах хөрөнгө оруулалтад баталгаа шаарддаг журамтай бол тохиолдол тус бүрийг судалж үзсэний дараа энэхүү Талын иргэд, компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг, харьяа тэнгисийн газарт оруулсан хөрөнгөд баталгаа гарган өгч болно.

Гэхдээ дээр дурдсан баталгааг Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг, харьяа далай, тэнгисийн газарт хөрөнгө оруулах иргэд, компани хэлэлцэн тохирогч нөгөө Талаас албан ёсны зөвшөөрөл урьдчилан олгосон нөхцөлд л гаргаж болно.

#### Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд компанийн хооронд гарсан хөрөнгө оруулалттай холбогдсон аливаа маргааныг оролцогч Талууд хоорондоо боломжийн хэрээр нөхөрсгөөр шийдвэрлэнэ.

Маргаанд оролцогч аль нэг Тал гомдол мэдүүлсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд маргааныг шийдвэрлээгүй бол маргааныг оролцогч аль нэг Талын хүсэлтээр "Улс болон бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай" 1965 оны 3 дугаар сарын 18-нд нээгдсэн Вашингтоны Конвенцийн дагуу байгуулагдсан хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн арбитрийн шүүх /ХОТШОУАШ/-д мэдүүлнэ.

8.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Тал өөрийн иргэд, компанид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг, харьяа тэнгисийн газарт оруулсан хөрөнгийнх нь хувьд өгсөн баталгааныхаа дагуу төлбөр хийж буй бол энэ тохиолдолд дурдсан иргэд, компанийн үйл ажиллагаа болон эрхтэй холбогдсон зүйлийн бүрэн эрх нь хэлэлцэн тохирогч нэгдүгээр Талд шилжинэ.

Ийнхүү Хэлэлцэн тохирогч нэг Талаас баталгааны төлбөрийг гүйцэтгэх нь баталгаа гаргасан этгээдээс маргаантай асуудлыг ХОТШОУАШ-д мэдүүлэх, шийдвэрлүүлэх эрхийг хөндөхгүй.

Аравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын хүсэлтээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэд, компанийн ашиг сонирхлыг хөндөхгүйгээр Талууд хөрөнгө оруулалтын асуудлаар шинээр тохиролцоонд хүрээд, тэр нь энэхүү Хэлэлцээрээс илүү таатай нөхцөл олгож байвал Хэлэлцээрийн нөхцөлийг хөндөхгүйгээр хөрөнгө оруулалтыг сүүлчийн тохиролцооны нөхцөлөөр зохицуулж болно.

Арван нэгдүгээр зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа маргааныг боломжийн хэрээр дипломат шугамаар шийдвэрлэнэ.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг тал гомдол мэдүүлсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд маргааныг шийдвэрлээгүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр маргааныг Арбитрийн шүүхэд шилжүүлж болно.



3. Шүүхийг тухай бүр дараах байдлаар байгуулна.

Хэлэлцэн тохирогч Тал бүр нэг арбитрчийг томилох бөгөөд ийнхүү хоёр талаас томилогдсон арбитрчид харилцан тохиролцсон үндсэн дээр гуравдагч улсын иргэн гуравдагч арбитрчийг сонгоно. Хэлэлцэн тохирогч хоёр Тал гуравдагч арбитрчийг шүүхийн даргаар томилно. Маргааныг арбитрт оруулах бодолтой байгаа Хэлэлцэн тохирогч нэг Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа энэ талаар мэдэгдсэнээс хойш 2 сарын хугацаанд бүх арбитрчдыг сонгоно.

4. Арван нэгдүгээр зүйлийн 3 дугаар заалтад дурдсан хугацаанд арбитрийн шүүхийг байгуулж чалаагүй бөгөөд өөрөөр тохиролцоонд хүрээгүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Тал шаардлагатай томилолт хийлгэхээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг урина. Хэрэв Ерөнхий нарийн бичгийн дарга нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн байх буюу бусад шалтгаанаар дээрх үүргийг гүйцэтгэж чадахгүй бол түүний дараах зиндааны бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Улсын иргэн бус хун шаардлагатай томилолтыг хийнэ.

5. Шүүх шийдвэрээ олонхийн саналаар гаргана. Энэхүү шийдвэр нь эцсийнх болох бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд түүнийг заавал биелүүлэх үүрэгтэй байна.

Шүүх дэгээ өөрөө тогтооно. Шүүх нь Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр шийдвэрээ тайлбарлана. Онцгой тохиолдлын үүднээс Шүүх өөрөөр шийдээгүй бол, арбитрчдын шан харамж зэрэг шүүхийн зардлыг хоёр Засгийн газар тэнцүү хувааж төлнө.

10.

Арван хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Тал бүр түүнийг хүчинтэй болгох талаар хууль зүйн бүхий л шаардлагыг биелүүлсэн тухайгаа харилцан мэдээлсэн өдрөөс хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх доод хугацаа нь 10 жил болно. Хэлэлцэн тохирогч нэг Тал түүнийг цуцлах тухайгаа дипломат шугамаар нэг жилийн өмнө бичгээр мэдэгдээгүй бол цаашид ч хүчин төгөлдөр хэвээр байна.

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаа дууссан тохиолдолд түүнийг хүчин төгөлдөр байх хугацаанд оруулсан хөрөнгө нь дараагийн 20 жилийн хугацаанд Хэлэлцээрийн заалтуудад дурдсан хамгаалалтад байна.

Хэлэлцээрийг 1991 оны II дүгээр сарын 8 - ны өдөр Улаанбаатар хотноо монгол, франц хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

